



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№114 /114/

2021.08.17

ҮЙЛ ЯВДАЛ

ӨДӨР ТУТМЫН “ДУУЛГА-НЬЮС”



Батлан хамгаалах яамны харьяа “Соёмбо” редакцын “Дуулга” студи нь төрийн батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах замаар хүүхэд, залуучуудад эх оронч, үндэсний үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм.

“Дуулга” студийн хамт олон 7 хоног тутмын “Эх орны төлөө” 30 минутын багтаамжтай нэвтрүүлгийг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, телевизийн стандартад нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж, МҮОНРТ-ийн нэг, хоёрдугаар сувгаар Ням, Даваа гаригуудад орон даяар нэвтрүүлэхийн зэрэгцээ цаг үеийн мэдээ, сурвалжилгыг “Монголын мэдээ” суваг болон бусад арилжааны телевизүүдийн мэдээллийн хөтөлбөрүүдээр нэвтрүүлдэг.

Тэгвэл цаашид тус студийн хамт олон “DUULGA-NEWS” өдөр тутмын цахим дүрст мэдээллийг санаачлан үзэгч Та бүхэнд толилуулахад бэлэн болжээ. Энэхүү цахим мэдээллээр

“Соёмбо” редакц “Дуулга” студи

дамжуулан Батлан хамгаалах салбарт өрнөж буй үйл явдлыг цаг алдалгүй түргэн шуурхай хүлээн авч үзэх боломжтой юм. Ийнхүү үзэгч олондоо Батлан хамгаалах салбарт өрнөж буй мэдээ мэдээллийг дахин нэг шинэ сувгаар шуурхай хүлээн авах боломжийг бүрдүүлэхээр зорин ажиллаж байгаа бөгөөд “Duulga-News” цахим дүрст мэдээллийг БХЯ, ЗХЖШ-ын вэйб сайт болон “Дуулга” студи, “Соёмбо” сонины пэйж хуудсуудаар дамжуулан энэ өдрөөс эхлэн хүргэх болно.

Мөн БХЯ-ны харьяа байгууллага, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, аймаг, нийслэл, дүүргийн Цэргийн штаб, хилийн чанадад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багууд өөрийн байгууллагад болж буй үйл явдлуудыг “Duulga-News” өдөр тутмын цахим мэдээллийн сувгаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх нь нээлттэй тул Та бүхэн мэдээ, мэдээллээ холбогдох материалын хамт бидэнд soyombo@mod.gov.mn цахим шуудангаар ирүүлж хамтран ажиллахыг хүсье.

ЦАХИМ ШУУДАНД

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ ШАТНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны сургалтыг хээрийн байрлалд 8 дугаар сарын 2-16-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалтаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд зэвсэг, техник дээр ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх, Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн хэргийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилтыг тавьж хэрэгжүүллээ.

Хээрийн байрлалыг Өлзийт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт “Цэргийн дүрэм”, “Цэргийн алба зохион байгуулах заавар”-ын дагуу эрүүл ахуй, хөдөлмөр аюулгүй байдлын стандарт шаардлагад

нийцүүлэн төхөөрөмжлөн зохион байгуулсан бөгөөд 2021-2023 онд цэргийн дүйцүүлэх албыг хаах 40 иргэнтэй цэргийн дүйцүүлэх алба хаах гэрээг байгуулан сургалтад бүрэн хамрууллаа.

Сургалтын явцад Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг орон нутагт сурталчлах, иргэдийн аюулгүй зорчих боломжийг хангах зорилгоор Өлзийт сумын Засаг даргын Тамгын газартай хамтран үерт эвдэгдэн зорчих хэсгүүд нь саатсан Өлийн давааны замыг засварлах ажлыг мөн хийж гүйцэтгэж сумын удирдлагууд болон нутгийн иргэдэд хүлээлгэн өглөө. Хээрийн байрлалд байх хугацаанд сургалтад хамрагдаж буй бүрэлдэхүүний дунд үндэсний бөхийн барилдааныг зохион байгууллаа.

Хошууч Г.БАТ-ӨЛЗИЙ

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



Зэвсэгт хүчний 327 дугаар анги Батлан хамгаалахын сайдын баталсан журмын дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн түвшин тогтоох үзлэгийг Зэвсэгт хүчний 327 дугаар ангид энэ сарын 11-13-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.

Шалгалтаар Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар тусгай салбар, Дорнод аймгийн Цэргийн штабын бүрэлдэхүүн хамрагдлаа. Энэхүү үзлэг цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагч нарын мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга харууллага, ёс зүйн



хэм хэмжээ, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг тогтоож цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой явагдаж өндөрлөлөө.

Тус анги офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд биеийн тамирын хотхон, онолын шалгалтын болон ажлын гүйцэтгэл шалгах байрыг сайтар бэлтгэснээр үзлэг явуулах боломжийг бүрдүүлж, зохион байгуулалтын өндөр түвшинд хамрагдлаа.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.850.0	2.853.0
EUR 🇪🇺	3.50.0	3.360.0
CNY 🇨🇳	440.0	441.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.58	26.02
KRW 🇰🇷	2.42	2.51

ЗУРХАЙ

2021.08.17 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 10/

НАМРЫН ТЭРГҮҮН УЛААН БИЧ САРЫН ДӨРВӨН НОГООН УЛААЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Эрч хүч ихсэнэ

Наран ургэх, шингэх:

05:50-20:03

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Нэр өнгө

Суудал:

Уул

Энэ өдөр үхэр, тогой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, таенай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

ДОРНЫН ЗУРХАЙ: Үс засуулбал Эрч хүч ихсэнэ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 184,652 +1061	ЭДГЭРСЭН 168,874 +1674	НАС БАРСАН 880 +4
-----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4352 +78	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 159 +19	ЭДГЭРСЭН 4110 +22
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 208,642,293
Эдгэрсэн Нийт: 187,036,058
Нас барсан Нийт: 4,382,884

КОВИД-19

Өвдөөд эдгэрсэн таны, миний хайртай хүмүүс **НИЙГИЙН ГАДУУРХАЛД** өгөх ёстой!

КОВИД-19-өөр өвдсэн хүмүүсийг нийгмийн гадаргаас болж сэтгэлийн түгшүүр, **БУХИМДАЛ & ЦОЧРОЛ**-д ордог.

Өвдөөд эдгэрсэн хүмүүсийг ялгаруулан гадаргах нь **ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛГҮЙ & ХҮНЛЭГ БҮС** зүйл юм.

КОВИД-19-өөр өвдөөд эдгэрсэн хүнтэй харилцах нь **АЮУЛГҮЙ** бөгөөд бусдыг **ХАЛДВАРЛУУЛАХҮЙ**.

Эдгэрсэн хүн вирусийн калдварыг **ДАМЖУУЛДАГҮЙ** болохыг шинжлэх ухаанаар баталсан.

ЦАХИМ ШУУДАНД

ЭХ ОРОН 100



Зэвсэгт хүчний 110 дугаар анги
Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жил, Залуучуудын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан "Эх орон 100" сургалт нөлөөллийн үйл ажиллагааг Орхон аймаг дахь Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн


газрын харьяа Залуучуудын ордны хамт олон Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулав.

Эх орныхоо төлөө цэргийн албаа нэр төртэй хааж байгаа залуучуудад гэр бүлийн харилцаа, хууль эрх зүйн сургалт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, санхүүгийн

мэдлэг олгох тэдэнд олон талт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг явууллаа. Мөн сургалтын хажуугаар хөгжөөнт тоглоом, урлагийн номер явагдаж ангийн хугацаат цэргийн алба хаагчдын сэтгэл санааг дээшлүүлж, урамшуулан инээд бэлгэлсэн сайхан арга хэмжээ боллоо.

Дэслэгч Б.ХАЛИУН

E-MONGOLIA СИСТЕМД 60 МЯНГА ИРГЭН САНАЛ, ГОМДОЛ ИРҮҮЛЖЭЭ



Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем e-Mongolia 2021 он гарснаас хойш нийт 60,000 орчим иргэний санал, гомдол, шүүмжлэлийг хүлээн авсан бөгөөд холбогдох албаныхан иргэдийн санал, гомдлыг шийдвэрлэсэн байна.

E-Mongolia системд дуудлага нь лавлагаа, үйлчилгээтэй холбоотой 21 367 дуудлага,

системд нэвтрэх, бүртгэлтэй холбоотой 11 508, аж ахуй нэгж тоон гарын үсгээр нэвтрэхтэй холбоотой 2002, бусад үйлчилгээтэй холбоотой 6000 орчим байна. Мөн олон шатлалт үйлчилгээ дунд гадаад паспорттой холбоотой 3363, иргэний үнэмлэхтэй холбоотой 2588, жолооны үнэмлэхтэй холбоотой 1815 дуудлага хүлээн авчээ.

Үүний зэрэгцээ e-Mongolia системийн ашиглалттай холбоотой иргэдийн санал, гомдол, шүүмжлэлд үндэслэн e-Mongolia системд пин кодоор нэвтрэх шийдлийг бий болгоод байгаа бөгөөд иргэд e-Mongolia системд нэвтрэх орсны дараагаар пин кодоо үүсгэн, цаашид үүсгэсэн пин кодоороо хялбар нэвтрэх боломжтой юм. Мөн танилт, нэвтрэлт, үйлчилгээ авах шийдлийг илүү хялбар, ойлгомжтой болгох технологийн шийдлийг нэвтрүүлж байгаа бөгөөд тун удахгүй энэхүү шийдлээ танилцуулах ажээ. Өнөөдрийн байдлаар e-Mongolia системд нийт 4 сая орчим үйлчилгээний хүсэлт хүлээн авснаас 3.5 сая гаруй үйлчилгээг иргэдэд амжилттай үзүүлсэн байна.

Тус системээс төрийн 56 байгууллагын 539 үйлчилгээг авах боломжтой бөгөөд санал, шүүмжлэл, гомдлоо хэрхэн шийдвэрлүүлэхээ мэдэхгүй иргэд 11-11 дугаарт залган 1 гэсэн товчийг даран холбогдох эсхүл https://www.facebook.com/emongolia фэйсбүүк хуудсанд хандах боломжтой аж.

УЛААНБААТАР ХОТОД ӨНӨӨДӨР 4969 ИРГЭНИЙГ ДАРХЛААЖУУЛНА

Улаанбаатар хотод өнөөдөр суурин 39 цэгт 47 багийн 324 эмч, ажилтан

ажиллаж, 4969 иргэнийг дархлаажуулахаар төлөвлөжээ.

Шинжилгээний болон дархлаажуулалтын цэгүүдийг дүүрэг тус бүрээр танилцуулж байна.

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

2021.08.16-08.20-нд АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН БАЙРШИЛ

Д/Д	ДҮҮРЭГ	ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ГАЗАР	БАЙРШИЛ	НЭГ АЖИЛЛАХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТОО
1	Баянгол	Эмүжин төв	Өргөө кино театрын урд байрлах Петровис ШТС-ын Баруун урд талд, Хөжлөл хотхоны урд	150
2	Сүхбаатар	СБД-ийн ЗМТ-ийн нэг цэгийн үйлчилгээ	100 айл, Жоби төвийн зүүн талд	120
3	Чингэлтэй	ЧД-ийн ЗМТ-ийн нэгдсэн эмнэлэг	СУИС-ын замын урд ЧД-ийн нэгдсэн эмнэлгийн хашаан дотор	100
4	Баянзүрх	Шинэжилгээ авах явуулын баг	Баянзүрх дүүргийн Авто энгэрлөгөөний төвийн зогсоол	100
5	Сонгинохайрхан	Шинэжилгээ авах явуулын баг	5 шарын төмөр замын гарамын урд байрлах Номын агуулах байрны гадаа	150
6	Хан-Уул	Шинэжилгээ авах явуулын баг	Буянт-Ухаа өлсрт цогцолборын гадаа талбай	100

09:00-12:00 ЦАГИЙН ХООРОНД ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭ АВНА

ОХУ-Д СУРДАГ ОЮУТНУУДЫГ ТАНХИМЫН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОВ



Монгол Улсаас сайд И.В.Моргуловыг ОХУ-д суугаа Онц Бүрэн эрхт Элчин сайд Д.Даваа ОХУ-ын Гадаад хэргийн орлогч Монгол, Оросын

дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэх хамтарсан төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ОХУ-д хийхээр төлөвлөж буй айлчлалын бэлтгэл ажлын явцын талаар хэлэлцжээ. Мөн Элчин сайдын яамны дэргэдэх Худалдааны төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа болон ОХУ-д суралцдаг монгол оюутнуудыг 9 дүгээр сараас танхимын сургалтад хамруулах боломжийг хангах талаар санал солилцсон байна.

ЦЭЦЭРЛЭГИЙН СУРГАЛТЫГ ДАРААХ ТОХИОЛДОЛД ЗАЙН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛНЭ



Хичээлийн шинэ жил хоёр долоо хоногийн дараа танхимаар эхлэх гэж байна. Харин цэцэрлэгийн сургалтыг дараах тохиолдолд зайн сургалт руу шилжинэ хэмээн БШУЯ-наас мэдээллээ.

- Нэг ангид нэг үүхэд өвчилбөл 14 хоногийн хугацаагаар зайн сургалт руу шилжинэ
- Тухайн давхарт 3 бүлэгт өвчлөл гарсан тохиолдолд ангийн байрлааас хамаарч корпус болон давхраар хэсэгчлэн хаана
- Өөр хоорондоо хамааралгүй байршилтай гурав болон түүнээс дээш бүлэгт халдвар бүртгэгдвэл цэцэрлэгийг

бүхлээр нь зайн сургалтад шилжүүлнэ.

4 болон 5 настай хүүхдүүдийг эцэг эхийн хүсэлтэд үндэслэн 9 дүгээр сарын 1-нээс танхимын сургалтад хамруулна. Цэцэрлэгийн анги танхимын зай талбайгаас хамаарч нэг бүлэгт 15-25 хүүхэд хичээллэнэ. Ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг эхний ээлжид гурван сар хэрэглэх байдлаар бэлтгүүлнэ. Танхимын сургалтад хамрагдаагүй хүүхдийг зайн сургалтад хамруулна. Шинээр элсэх 4 болон 5 настай хүүхдийн элсэлт энэ сарын 16-25-ны өдрүүдэд болно.

2 болон 3 настай хүүхдүүдийг халдварын эрсдэлийн үнэлгээ хийгдсэний дараа ямар үе шаттайгаар хэрхэн цэцэрлэгт нь хамруулах талаар тухайн үед нь шийдвэр гаргаж ажиллах болно.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд эцэг эхчүүдийн оролцоо чухал бөгөөд дараах дэглэмийг мөрдөхийг зөвлөж байна.

- Гэр-цэцэрлэг-гэрийн хооронд амны хаалт тогтмол зүүлгэх /ангид маск зүүхгүй/
- Гар халдваргүйжүүлэгчийг бэлтгүүлэх
- Гэртээ ам хоолойг байнга зайлуулах, гарыг тогтмол угаалгах
- Шүдийг өглөө оройд гэртээ сайтар угаалгах
- Өвчний шинж тэмдэг илэрсэн нөхцөлд цэцэрлэгт явуулахгүй байх
- Бага насны хүүхдээ дагуулж олон нийтийн газраар явахгүй байх
- Зайн сургалтын үед хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр багштай хамтран ажиллах

Эх сурвалж: БШУЯ

ЭНЭ САРААС ЭХЛЭН ХОЁР ДАВХАР 10 АВТОБУСЫГ ҮЙЛЧИЛГЭЭНД ГАРГАНА



Хичээлийн шинэ жил эхэлж нийслэлд зорчих хөдөлгөөн ихсэхээс өмнө нийтийн тээврийн парк шинэчлэлийг эхлүүлж байгаа талаар Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газраас мэдээллээ. Тодруулбал, энэ сарын 25-наас эхлэн Нийслэлийн нийтийн тээвэрт 25-30 хүний суудалтай, хоёр давхар автобусыг үйлчилгээнд явуулахаар болов. Ийм 10 шинэ автобусыг гаргаж иргэдэд

үйлчлэх юм байна. Ингэснээр хотын түгжрэл 5 хувиар буурна гэж тооцоолжээ.

Нийтийн тээвэрт нэг автобусны ашиглалтын хугацааг 9-12 жилээр тооцдог байна. Үйлчилгээнд 12 болон түүнээс дээш жил явсан автобуснуудыг энэ жилээс шинэчилж эхэлж байна. Эхний ээлжид ашиглалтын хугацаа дууссан, угаа хаяж буй 30 автобусыг паркаас хасан акталжээ. Энэ

жил 200 автобусыг шинэ, том оврын, бөөнөөр нь тээвэрлэх багтаамж ихтэй автобусаар шинэчилнэ. Ингэснээр хөдөлгөөний эргэлт сайжирч авто замын хөдөлгөөний түгжрэл 50 хувиар багасна гэж байна.

Иргэд автобус хүлээж суухдаа нэг цагаас илүү хугацааг зарцуулж байгаа бол энэ нь үр ашгийг бууруулж байна. Мөн нэг цэгээс нөгөөд 15-20 минутын дотор зорчих учиртай. Ийм нөхцөл байдлыг бүрдүүлэхэд нийтийн тээвэр багтаамж ихтэй, түргэн шуурхай үйлчилдэг байх ёстой. Нийслэлийн Автотээвэр хариуцсан төслийн удирдагч Б.Одсүрэн цаашид нийслэлд RTV тээвэр буюу хөнгөн метро зэрэг төслийг хэрэгжүүлэхээр тооцоо судалгааг хийж буйг дуулгаж байна.

Нийслэлд хоёр давхар шинэ автобуснууд Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт эхний ээлжид гаргах аж.